

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2024/11

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.XI	2023.XI	2024.X	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 3-р улирал	их наяд ₮, оны үнээр	56.1	46.5	-	-	-	-	5.0% ▲
Инфляц	хувь	8.1%	8.6%	7.0%	1.7% ▲	-	7.7% ▲	0.5% ▲ нэгж хувиар
Ажилгүйдлийн түвшин	хувь	6.1% 2024 оны УЗ	5.2% 2023 оны УЗ	5.8% 2024 оны У2	-	0.3% ▲ нэгж хувиар	-	0.9% ▲ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1,373	1,947	1,523	150 ▼	-	-	-3,320 ▼
Ам.долларын ханш	төгрөг	3,412.7	3,440.6	3392.00	20.7 ▲	-	-	-27.8 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	4,029.3	5,435.6	3,627.4	402 ▲	-	-	-1,406 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	74.0	60.0	65.9	-	-	-	14.0 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1,514.2	1,393	1357.9	-	-	-	121.2 ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	10%	13%	10%	-1%	-	0%	-3%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.9	4.3	4.7	5.61% ▲	-	-	15.48% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.78%	8.11%	5.82%	0.04% Нэгж хувиар ▼	-	-	-2.33 нэгж хувиар ▼

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

Инфляц өмнөх сараас 1.7 хувиар өсөв.	2024 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгийн үнэ 7.3 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 8.4 хувиар, барааны бүлгийн үнэ 6.1 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 14.6 хувиар өсжээ.
--------------------------------------	--

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Бодлогын хүүг 10 хувь хэвээр үлдээв.	2024/12/13	Монголбанкны Мөнгөний бодлогын хороо хуралдаж Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах, Банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, харгалзан 11 хувь болон 16 хувьд хүргэхээр шийдвэрлэлээ.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График


#### Нөлөөлөл

#### Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.1 хувь, өмнөх оны эцсээс 7.7 хувь, өмнөх сараас 1.7 хувиар өссөн байна. 2024 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгийн үнэ 7.3 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 8.4 хувиар, барааны бүлгийн үнэ 6.1 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 14.6 хувиар өсжээ.

#### Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 11 дүгээр сард 3,412.77 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 27.5 төгрөгөөр суларч, өмнөх сараас 20.7 төгрөгөөр чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 5.61%-р, өнгөрсөн жилийн мөн үеэс 15.48%-р тус тус өсөж, 4.9 тэрбум ам.долларт хүрэв.

#### Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 27.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.2 (28.7%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 26.1 их наяд төгрөгт хүрч, 5.4 (26.0%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний 11 сард 24.7 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

#### Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 11 сард нийт 158 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 25.2 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 14.6 тэрбум ам.доллар, импорт 10.6 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 4.0 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Экспорт 2024 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеэс 781.7 сая ам.доллороор өсөхөд зэсийн хүдэр, баяжмал 528.1 сая ам.доллар, алт 181.0 сая ам.доллар, төмрийн хүдэр, баяжмал 153.3 сая ам.доллороор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

#### Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 11-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 11-р сар 2024 он, Монголбанк](#)
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.monqolbank.mn](http://www.monqolbank.mn)